

**“Цөлийн сарнай” асрамжийн газарт зохиосон  
“Уншсан номоо хуваалцъя” сэдэвт номын сэтгэгдлийн уралдаан**

ШУТИС-ийн ГХС-ийн Ази судлалын тэнхимийн багш Т.Мөнхжаргал санаачлан “Цөлийн сарнай” асрамжийн газрын хүүхдүүдийн дунд уншсан номын сэтгэгдлийн уралдааныг 2021 оны 1 сарын 25-аас 2 сарын 8 хүртэл хугацаанд зохион байгууллаа. Уг уралдааны шагналын санд зориулж 400 гаруй мянган төгрөгийг ГХС-ийн багш нарын хандиваар бүрдүүлж хүүхдүүдийг шагналаа. Асрамжийн газрын хүүхдүүд номтой нөхөрлөх, номоор дамжуулан ертөнцийг танин мэдэх, уншсан зүйлээ эргэцүүлэх, өөрийн санаа бодлоо илэрхийлж сурахад дэмжлэг үзүүлж, тэдний хүмүүжил төлөвшилд сайнаар нөлөөлөх, эх хэлний мэдлэгээ сайжруулахыг урамшуулахаас гадна цар тахлын үед сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг болох зорилгоор уралдааныг зохион байгуулсан юм.

“Цөлийн сарнай” Сан ТББ 2007 онд байгуулагдсан. Хүчирхийлэлд өртсөн охидыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх асрамжийн газар юм. Үйлчлүүлж байгаа зорилтот бүлэгт гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч охид, бүтэн өнчин хүүхдүүд хамаардаг. Өнөөг хүртэл 4-22 насны 150 гаруй охидод урт, богино хугацаагаар асрамж халамжийн үйлчилгээ үзүүлээд байна. Охидын зарим нь сар болоод гэр рүүгээ буцдаг бол зарим нь 7 жил асрамжийн газарт амьдрах зэргээр асрамжийн газарт байрлах хугацаа янз бүр. Асрамжийн газрын санхүүжилтыг хандив, төслөөр шийдвэрлэдэг.

Одоогийн байдлаар 9 ажилтан ажиллаж, 24 охиныг асарч байгаагаас хамгийн бага нь 3 настай, хамгийн том нь 24 настай хөгжлийн бэрхшээлтэй, бүтэн өнчин. Эдгээр хүүхдүүдээс 3 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, 3 оюутан, бусад нь ЕБС-ийн сурагчид байна. 2 охины хамааралтай шүүх ажиллагаа дуусаагүй байгаа.

Ковид 19 цар тахалтай холбоотойгоор зарим хүндрэлүүд гарч байна. Үүнд: хөл хорио зэргээс санхүүжилт багассан, хүүхдүүд танхимаар хичээллэх боломжгүй учраас ажилтнуудын ажлын ачаалал маш их нэмэгдсэн, онлайн сургалт орж байгаа учраас телевизийн хүрэлцээ муу. Мөн насанд хүрсэн бүтэн өнчин охидын асуудал, тухайлбал цаашид хаана хэнтэй амьдрахыг шийдэхэд бэрхшээлтэй байна.

ШУТИС ГХС-ийн багш нараас “Цөлийн сарнай” асрамжийн газарт зориулсан хандив

№	Нэр	Тэнхим	Мөнгөн дүн
1	Уранбилэг	ХХШТ	₮ 10,000.00
2	О.Золзаяа	ХХШТ	₮ 20,000.00
3	Дэлгэрмаа	АСТ	₮ 30,000.00
4	Чойжилмаа	АСТ	₮ 10,000.00
5	Түяа	ХХШТ	₮ 10,000.00
6	Ч.Оюунгэрэл	АСТ	₮ 30,000.00
7	Долгорсүрэн	АХСТ	₮ 20,000.00
8	Бигэрмаа	АСТ	₮ 15,000.00
9	Эрдэнэзаяа	АСТ	₮ 10,000.00
10	Түяа	АСТ	₮ 10,000.00

11	Нямдолгор	АХСТ	₮ 10,000.00
12	Мөнхдэлгэр	ХХШТ	₮ 10,000.00
13	Номиндалай	АСТ	₮ 30,000.00
14	Арваазана	АХСТ	₮ 20,000.00
15	Мөнхцэцэг	ХХШТ	₮ 10,000.00
16	Галтмаа	АСТ	₮ 10,000.00
17	Баасанжаргал	АСТ	₮ 10,000.00
18	Ундармаа	АСТ	₮ 10,000.00
19	Мөнгөнцэцэг	АСТ	₮ 10,000.00
20	Чимэдлхам	Дэд захирал	₮ 20,000.00
21	Т.Мөнхжаргал	АСТ	₮ 33,700.00
22	Т.Гэрэлмаа	АХСТ	₮ 30,000.00
23	Ж.Ганцэцэг	АХСТ	₮ 40,000.00
Нийт дүн			₮ 408,700.00

Номын сэтгэгдлийг хамгийн сайн бичсэн 10 сурагчийг шагнаж урамшуулав.

1-р байр 1 хүүхэд: 40 мянган төгрөгтэй хадгаламжийн дэвтэр, хувцас

2-р байр 2 хүүхэд: 30 мянган төгрөгтэй хадгаламжийн дэвтэр, хувцас

3-р байр 3 хүүхэд: 30 мянган төгрөгний үнэ бүхий хувцас

Тусгай байр 4 хүүхэд: 20 мянган төгрөгний үнэ бүхий хичээлийн хэрэгсэл

Бусад хүүхдүүдэд үзэг, дэвтэр бэлэглэлээ.



